

**МЕКСИК:**  
**ХОСЕ АДРИАН**

ЭРХИЙНХЭЭ  
ТӨЛӨӨ  
БИЧИЦГЭЭЭ

ЭМНЕСТИ  
ИНТЕРНЭШНИЛ



# ЦАГДАА НАР БАРИВЧЛАН, ЗОДЖЭЭ



# ХОСЕ АДРИАН

## МЕКСИК

Мексикийн ядуусын хороололд амьдардаг 14 настай Хосе Адрианыг хичээлээ тараад харьж явахад нь цагдаа нар барьж аван, зодож, хүчээр машиндаа суулган цагдаагийн хэлтэст авчран гавлаж орхижээ. “Тэд намайг бараг хагас цаг хэртэй тэнд байлгаж, цээж рүү цохиж, нүүр рүү алгасан” хэмээн тэр хэлсэн юм. Сонсголын бэрхшээлтэйн улмаас Адриан цагдаа нартай хэл нэвтрэлцэж чадаагүй байна.

Хэсэг залуучууд маргалдах явцдаа цагдаагийн машинд гэмтэл учруулсны үр дагаврыг Адриан хүүд ийнхүү тохжээ. Цагдаа зөвхөн Адрианыг баривчилсан ба хүүд юу ч тайлбарлаагүй, эцэг эхэд нь ч мэдэгдээгүй байна. Мексикт ядуу, ялгаварлагдсан уугуул иргэдийг золиос болгодогын нэг жишээ энэ юм.

Хүүгээ суллуулахын тулд Адрианы эцэг эх торгууль төлж, эргүүлийн машинд учирсан хохирлыг барагдуулах шаардлагатай болсон ба энэ нь тэдний хувьд хэзээ ч төлж дийлэхээргүй их мөнгө байв.

Олон жил шударга ёсны төлөө явсны эцэст 2019 оны эхээр Адриан сонсголын аппараттай болж, энэ бүхнийг мартаж, ирээдүйдээ анхаарахыг хүсч байгаа ч түүнийг хохироосон цагдаа ял шийтгэлгүй үлдсэн юм. Адрианы гэр бүлийнхэн засгийн газраас алдаагаа засч залруулахыг хүлээж, найдсаар байна. “Би шударга ёсыг л хүсч байна” хэмээн Адрианы ээж өгүүлсэн юм.

## МЕКСИКИЙН ЭРХ БАРИГЧ НАРТ ХАНДАН ЗАХИДАЛ БИЧИЦГЭЭ

Адрианд учруулсан хохирлыг барагдуулж, хэрэг үйлдсэн цагдаа нарыг шүүхээр оруулж хариуцлага тооцохыг шаардацгаая.

### **Governor of Yucatán State:**

**Lic. Mauricio Vila Dosal**

Palacio de Gobierno Calle 61  
x 60 y 62

Col. Centro, C.P. 97000

Mérida, Yucatán, México

Email:

despachogobernadorucatan@gmail.com

Twitter:

@MauVila, @GovYucatan

Salutation: Dear Governor

## АДРИАНД ЭВ САНААНЫ НЭГДЛЭЭ ИЛЭРХИЙЛЭЭРЭЙ.

Шударга ёсны төлөөх тэмцлийг нь дэмжиж байгаагаа илэрхийлсэн захидал, зурвас илгээгээрэй. mexteam@amnesty.org хаягаар илгээнэ үү.

### **Amnistía Internacional México**

Dr. José María Vertiz 1196

Letran Valle

03650 Ciudad de México

CDMX, Mexico

**ЗАХИДАЛ БИЧИЖ  
ВӨРЧЛӨЛТ ХИЙЦГЭЭ**

December 2019

Index: AMR 41/0750/2019 English

Images: cover: © Amnesty International  
(Main image), © Addicted04 (CC)

Back page: © Amnesty International